

Ариун ЯВДЛЫН ХУУЛЬ





Тэнгэрлэг Эцэг та нарт хайртай бөгөөд өнөөдөр мөн үүрд та нарыг аз жаргалтай байхыг хүсдэг. Тэрээр та нарт туслахын тулд Өөрийн бошиглогчдоор дамжуулан зөвлөгөө мөн зарлигуудыг өгдөг. Нэг зарлиг болох ариун явдлын хууль буюу бэлгийн харьцааны цэвэр байдал нь та нарын амар амгалан болон аз жаргалтай байдалд чухал юм. Их Эзэн эхлэлээс энэ хуулийг тогтоосон ба Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн үед Иосеф Смитэд үүний чухал байдлыг онцлон хэлсэн юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртэхэд тавигдах нэг шаардлага нь энэ зарлигт дуулгавартай байх явдал юм.

Ариун явдлын хууль гэж юу вэ?

Эхнэр нөхөр хоёрын хоорондох бие махбодын дотно харьцаа нь Түүний хүүхдүүдэд зориулсан Бурханы төлөвлөгөөний гайхамшигтай болоод нандин хэсэг юм.


Ариун явдлын хууль нь бэлгийн харьцааг эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондох гэрлэлтэнд хадгалахыг шаарддаг.

Энэ нь гэр бүлийн хүрээн дэх хайрын илэрхийлэл бөгөөд эхнэр нөхөр хоёрт хүүхэд төрүүлэх боломжийг олгодог. Үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой гэдгийг Бурхан зарлигласан билээ. Ариун явдлын хууль нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс гэрлэлтээс өмнө бэлгийн харьцаанд

орохыг хатуу цээрлэж мөн гэрлэлтийн дараа ч эхнэр нөхөртөө үнэнч, шударга байхыг шаарддаг.

Гэрлэлтэндээ дотно харьцаагаа хадгалахаас гадна бид өөрсдийн бодол санаа, үг хэл, үйл хөдлөлөө хянаснаар ариун явдлын хуулийг дагадаг. “Завхайрч болохгүй гэснийг та нар дуулсан: Харин би та нарт хэлье, эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм” (Матай 5:27–28) хэмээн Есүс Христ заасан билээ.





Яагаад би ариун явдлын хуулийг дагах ёстой вэ?

Тэнгэрлэг Эцэг та нарыг адисалж мөн хамгаалахын тулд ариун явдлын хуулийг өгсөн юм. Бүх нандин зүйлсийн адил эхнэр нөхрийн бие махбодын дотно харьцаа нь Бурханы удирдлагын дагуу байх ёстой. Хэрэв та нар ариун явдлын хуулийг дагавал та нар аз жаргал, амар тайван, өөрийгөө хүндэтгэх байдлыг мэдрэх болно. Та нар гэр бүлдээ итгэл найдварыг мэдэрч мөн өөрийгөө хянах чадвараар адислагдах болно. Ариун Сүнсний нөлөөгөөр дамжуулан Есүс Христийн сайн мэдээний адислалуудад та нар баясах болно.

Сатан хүмүүст гэрлэлтээс гадуурх бэлгийн харьцаанд орох нь хүлээн зөвшөөрөгдөх төдийгүй хүсүүштэй зүйл хэмээн итгүүлэхийг хичээдэг. Гэвч энэ нь ноцтой

нүгэл юм; Бурхан үргэлж Өөрийн хүүхдүүддээ ёс суртахуунтай, цэвэр ариун байхыг сургадаг (Египетээс гарсан нь 20:14, Алма 39:3–5-ыг үз). Энэ зарчим бол мөнхийн юм.

Хэрэв та нар ариун явдлын хуулиар амьдарвал, та нар:

- өөрсдийн амьдралд Ариун Сүнсийг урих болно.
- өөрсдийгөө хянах үед өөрийгөө илүү их хүндэтгэх байдлыг хөгжүүлнэ.
- өөрсдийн нөхөрлөлдөө илүү итгэлтэй байх болно.
- та нарыг хүрээлж буй хүмүүсийг хайрлах хайраар дүүрэх болно.

Ариун явдлын хуулийг зөрчих нь амьдрал бүтээ гэж өгсөн Бурханы хүчийг буруугаар ашиглаж байна гэсэн үг юм. Энэ байдал нь Түүнийг болон Түүний хүүхдүүдийг хүндэтгэхгүй байгааг харуулж байна. Энэ нь сүнслэг байдлыг мохоож мөн ихэвчлэн гай зовлон, сэтгэлийн шаналал, гэр бүл салалт, өвчин, үр хөндөлт руу хөтөлдөг. Ариун явдлын хуулийг зөрчдөг тэдгээр нь Сатаны нөлөөлөлд маш ихээр автдаг. Ийм нүгэл нь гэр бүлийн гишүүдэд болон бусдад ноцтой нөлөөлдөг.

Би хэрхэн ариун явдлын хуулийг дагах вэ?

Бурхан өөрийн хүүхдүүдээсээ ёс суртахууны өндөр жишигтэй байхыг шаарддаг. Ариун явдлын хуулийг

дагаснаар та нар таатай бус бодол санаа, үг хэл, үйл хөдлөлөө зөв бодол, үг хэл, үйл хөдлөлөөр солих ёстой. Доорх зарчмууд нь та нарт туслах болно:

Бодол санаа. Эерэг, бүтээлч бодол санаа нь эсрэг мөн ёс суртахуунгүй нэгнийг та нарын амьдралаас зайлуулдаг. Хэрэв та нар эрүүл саруул бодол санаа, үйл явдлаар амьдралаа дүүргэх юм бол та нарын боломж өсөн

“Бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёг, тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болох болно.”

С 6а Г 121:45

хөгжиж эсрэг бодлуудаа ялан дийлэх болно. Судар унших, гэр бүлдээ үйлчлэх, хичээнгүй ажиллах,





амралтынхаа үеэр зөв зохистой үйл ажиллагаа явуулах нь та нарыг бодол санаагаа хянахад чинь туслах болно.

Порнографийн бүх төрлөөс зайлсхий. Энэ нь донтуулж мөн сүйрүүлдэг юм. Энэ нь та нарын өөрийгөө хүндэтгэх болон амьдралын гоо үзэсгэлэнг үнэлэх үнэлэмжийг булаан авах болно. Бүдүүлэг, ёс суртахуунгүй байдал болон бодол санааг оюун санаандаа байлгахыг бүү зөвшөөр. Буруу замаар дүрсэлсэн мөн зурсан хүмүүний бие болоод бэлгийн харьцаанд уруу татсан ямар ч зүйлүүдийг бүү хар, бүү унш, бүү сонс. Бусдыг тачаангуй бодолтойгоор харахаас зайлсхий. Ямар нэгэн зүйлийг далдуур сануулсан болон тодорхой үзүүлсэн кино, телевизийн шоу, интернэт, хөгжим, ном, сэтгүүл, үйл ажиллагаанаас зайлсхий.

Хэл яриа. Бусдыг сайшааж дэмжсэн мөн хүчирхэгжүүлсэн хэл яриаг хэрэглэ. Бусадтай харьцахдаа доромжилсон, бүдүүлэг, бэлгийн харьцааны тухай ил тод яриа, тоглоом шоглоомоор ч гэсэн битгий ярь.

Үйл хөдлөл. Үргэлж бусдад хүндэтгэлтэйгээр ханд. Хувцаслалтандаа даруу бай. Хэрэв та нарын хүн бүр Бурханы хүүхэд гэдгээ санавал мөн Түүний төлөвлөгөөг дагахад бусдад туслахын тулд чадах бүхнээ хийвэл энэ нь та нарын ариун явдлын хуулийг дагах хүслийг тань хүчирхэгжүүлэх болно.

Гэрлэсэн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын сэтгэл хөдлөлийг бий болгох зүйлийг гэрлэлтээс гадуур

хийхгүй байх шийдвэрийг та нар яг одоо гарга. Өөр бусдад болон өөртөө тэдгээр мэдрэмжийг бүү төрүүл. Ижил хүйстэнтэйгээ явалдах болон ёс суртахуунгүй үйл ажиллагаануудад бүү оролц. Ариун явдлын хуулийг зөрчихөд та бүхнийг уруу татах тэдгээр үйл ажиллагаануудыг бүтээлч үйлс мөн хоббигоор соль. Эхнэр, нөхрүүд өөрсдийн хань ижилдээ бодол болон үйлсээрээ туйлын итгэлтэй бай.

Ариун явдлын хуулийг дагаснаар та нар Бурхантай илүү ойр байх болно. Гэхдээ Сатан та нарыг энэ зарлигыг зөрчүүлэхээр уруу татах болно. Та нарын ганцаардаж будилсан мөн гутарсан үеийг тэрээр мэддэг ба та нарыг сул дорой байхад тэр уруу татдаг. Тэнгэрлэг Эцэгээсээ тусламж хүсэн залбир, Тэрээр та нарт уруу таталтыг давах хүч чадлыг өгөх болно. (1 Коринт 10:13). Түүнд найдан тэдгээр зарчмуудыг дагах үед та нар уруу таталтыг давах боломжтой байх болно.

Ариун явдлын хуулиар амьдарснаар ирэх адислалууд

Хэрэв та нар ариун явдлын хуулиар амьдарвал та нар Ариун Сүнсний нөлөөг илүү их мэдрэх болно. Ариун Сүнсний удирдамжаар та нарын оюун ухаан хөгжиж, амьдралдаа илүү их зоригтойгоор бэрхшээлүүдтэй тулж, Бурханы дэмжлэг болон удирдамжийг мэдэрч, гэр бүлдээ мөн бусдад үлгэр жишээ байх



Та нар өмнө нь юу хийсэн чинь хамаагүй, одооноос эхлэн ариун явдлын хуулиар амьдарвал та нар агуу адислалуудыг авах боломжтой юм.

болно. Та нарт эхнэр эсвэл нөхрөө хайрлах хайр, та нарыг хайрладаг хүмүүсийн хайр илүү гүн гүнзгий, баялаг, утга учиртай байх болно. Та нар илүү их амар тайвныг мэдрэх болно.

Бурханы зарлигуудыг дагаснаар ирэх үнэн аз жаргал (Мозая 2:41) хийгээд “ёсон бус гэдэг нь хэзээ ч аз жаргал байгаагүй” (Алма

41:10) гэдгийг бид судраас сурч авдаг.

Хэрэв та нар ариун явдлын хуулийг зөрчвөл Бурхан та нарт нүглээ наманчлах, дахин цэвэр болох боломжийг өгсөн юм. Өмнө нь үйлдсэн гэм нүглээ яг одоо наманчил мөн энэ нандин хуулийн дагуу амьдрах шийдвэрийг гарга. Есүс Христийн Цагаатгал мөн чин сэтгэлийн наманчлалаар дамжуулан та нар өршөөгдөн амар тайвныг мэдэрч чадна.

НЭМЭЛТ СУДРУУД

Доорх асуулт болон судрууд нь энэхүү товхимол дахь зарчмуудыг илүү сайн судлахад туслах болно. Судрын тайлбар болон ишлэлүүд нь эдгээр зарчмуудын тухай нэмэлт мэдээлэл авахад та нарт туслах болно.

Ариун явдлын хуулийг дагана гэж юу гэсэн үг вэ? Энэ хууль яагаад чухал вэ?

Египетээс гарсан нь 20:14 (Библи, Хуучин Гэрээ)

Сургаалт Үгс 6:27–32 (Библи, Хуучин Гэрээ)

Тит 2:11–12 (Библи, Шинэ Гэрээ)

Алма 39:3–5 (Мормоны Ном, хуудас 382)

3 Нифай 12:27–30 (Мормоны Ном, хуудас 551;
Шинэ Гэрээний Матай 5:27–30)

“Гэр Бул: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” (Номлогчид болон Сүмийн гишүүд та нарт энэ материалын хуулбар, дор жагсаасан “Итгэлдээ Үнэнч байх нь”, “Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө” товхимолуудыг олж авахад тусална. Мөн та нар www.mormon.org хаягаар орж захиалж болно.)

“Ариун явдлын хууль” *Итгэлдээ Үнэнч байх нь*

Би ариун явдлын хуулийг дагахад хэрэгтэй хүч чадлыг хэрхэн олох вэ?

1 Коринт 10:13 (Библи, Шинэ Гэрээ)

Мозая 4:29–30 (Мормоны Ном, хуудас 188)

Алма 38:12 (Мормоны Ном, хуудас 381)

Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө товхимол



Би юу хийх ёстой вэ?

- **Мормоны Номыг үргэлжлүүлэн унш.**
Санал болгох уншлага: _____

- **Ариун явдлын хуулиар амьдар.** Энэ зарлигыг дагах тусламж гуйн залбир.
- **Энэ ням гарагт сүмийн цуглаанд оролц.**
- **Баптисм хүртэхийн тулд үргэлжлүүлэн бэлтгэ.**
Баптисмын огноо: _____
- **Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл www.mormon.org сайтаас үзнэ үү.**
- **Сэргээгдсэн сайн мэдээний талаар илүү их сурахын тулд номлогч нартай үргэлжлүүлэн уулз.**

Дараагийн уулзалт: _____

Номлогч нарын нэр, утасны дугаар:

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

www.mormon.org

Зургийн Тайлбар

Урд талын хавтсан дээр, Түүнийг Сонсоггун зургийн хэсгээс, Симон Дьювей. © Simon Dewey
хуудас 6, Аврагч Дел Парсон. © Del Parson
Хуудас 9, 13-ыг Wei-Hsiang Wang.

© 2007 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи хэлний зөвшөөрөл: 2/06.
Орчуулгын зөвшөөрөл: 2/06. Chastity-ийн орчуулга. Mongolian

MONGOLIAN



4 0201187363 3

01187 363